

БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ,
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани нь “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам” болон холбогдох бусад журам, зааврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж, тэдгээрт тусгасан мэдээ, мэдээллийг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Иймд Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл болон эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс 2017 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хууль, журмын дагуу зохих материалыг МХБ-д цаасаар болон цахим хэлбэрээр ирүүлэхийг мэдэгдэж байна. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 443 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 2.2-т заасны дагуу жилийн үйл ажиллагааны тайланг аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн хамт 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, хагас жилийн үйл ажиллагааны тайланг 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус тус ирүүлэх,
2. Дээрх журмын 3.2-т заасан тухай бүр нийтэд хүргэх мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдөрт багтаан ирүүлэх,
3. Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 244 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу ээлжит хурлаа зарлаж, материал шийдвэрээ хугацаанд нь ирүүлэх,
4. МХБ-ийн цахим хуудаст <http://mse.mn/content/list/110/0#/> байршуулсан загварын дагуу компанийн ерөнхий мэдээллийн маягыг бөглөн, энэхүү маягт болон Улсын бүртгэлийн ерөнхий газраар баталгаажсан дүрмийн хуулбарыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалд хавсарган ирүүлэх,
5. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23 дугаар зүйлийн 10-т зааснаар бүртгэлтэй хувьцаат компани нь жилийн үйлчилгээний хөлсийг тухайн оны I дүгээр улиралд багтаан Монголын хөрөнгийн биржийн дансанд төлөхөөр

туссан тул 2017 он болон өмнөх онуудын төлбөрийн үлдэгдлийг 2017 оны 3 дугаар сарын 30-ны дотор төлж, тооцоо нийлсэн акт үйлдэх,

6. Түүнчлэн 2016 онд бүртгэлийн гэрээгээ шинэчлэн байгуулаагүй компаниуд МХБ-ийн цахим хуудас [/http://mse.mn/content/list/110/0#/-T](http://mse.mn/content/list/110/0#/-T) байршуулсан гэрээний загварын дагуу гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан 2 хувь үйлдэж ирүүлнэ үү.

Та бүхнийг хүлээсэн үүргийнхээ дагуу нээлттэй ил тод байх зарчмыг сахиж, хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулан бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Хавсралт: Мэдээлэл ирүүлэх хуанли 2 хуудас, тооцоо нийлэх акт 2 хуудас, нэхэмжлэх 1 хуудас, нийт 5 хуудас

Холбогдох хаяг:

Хяналтын шалгалтын алба

Монголын хөрөнгийн бирж ТӨХК

Сүхбаатарын талбай-2

Улаанбаатар 15160, Монгол улс

Утас : (+976)-11-310517/5115, 5120, 5121/

Факс: (+976)-11-325170

Вэб : www.mse.mn

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х.АЛТАЙ

Хавсралт

МХБ-д мэдээлэл ирүүлэх хуанли

Нэг. Хугацаат тайлан, мэдээлэл

• **1 дүгээр улирал**

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Жилийн эцсийн санхүүгийн тайлан	ҮЦЗЗТХ 20.1.6, НББ хуулийн 10.3	02 сарын 10 -ны дотор /компанийн нэгдэл 03.01/
2	Ногдол ашиг тараах эсэх тухай шийдвэр	КТХ-ийн 46.5	Санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор буюу 02 сарын 19 -ны дотор
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл	КТХ-ийн 60.3, 60.4, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.8	03 сарын 21 -ны дотор +/3-5 хоног/
4	Аудитын дүгнэлт	ҮЦЗЗТХ 20.1.6, Аудитын тухай хуулийн 10.2, НББ хууль 9.7	ХЭХ-аас 2-оос доошгүй долоо хоногийн өмнө /ТӨХК 03.15 , Банк 03.31 /
5	Жилийн үйл ажиллагааны тайлан*	СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 2.2	03 сарын 31 -ний дотор /04.01-ний дотор/
6	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл	КТХ-ийн 74.1, ҮЦЗЗТХ 20.1.8, 56.1.6, 56.2.3, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.12	Хурал хуралдсанаас хойш ажлын 3-15 өдрийн дотор

• **2 дугаар улирал**

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах сүүлчийн хугацаа	КТХ-ийн 59.4	04 сарын 30 -ны дотор
	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл	КТХ-ийн 74.1, ҮЦЗЗТХ 20.1.8, 56.1.6, 56.2.3, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.12	Хурал хуралдсанаас хойш ажлын 3-15 өдрийн дотор /сүүлчийн хугацаа 05 сарын 20 -ны дотор/

- **3 дугаар улирал**

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Хагас жилийн санхүүгийн тайлан	НББ хуулийн 10.3, СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"1.7,	07 сарын 20 -ны дотор
2	Хагас жилийн үйл ажиллагааны тайлан*	СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 2.2, 2.4	08 сарын 01 -ний дотор

- **Бусад**

		Хууль, журмын заалт	Хугацаа
1	Ногдол ашиг хуваарилалтын тайланг ХЭХ-д тайлагнах, МХБ-д ирүүлэх	КТХ 46.14 КТХ 46.15	ХЭХ-ын өдөр хуваарилж дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор
2	Жилийн үйлчилгээний хөлс төлөх	МХБ-ийн Бүртгэлийн журам 22.7, Бүртгэлийн гэрээ 2.1.3, 2.4	03 сарын 31 -ний дотор
3	Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл	ҮЦЗЗТХ-56.1, 56.2, СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"3-р зүйл, 3.2	Тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын 1 өдрийн дотор

Товчилсон үгийн тайлбар:

КТХ - Компанийн тухай хууль

НББ хууль - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

ҮЦЗЗТХ - Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

ХЭХ- Хувьцаа эзэмшигчдийн хурал